



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/425

Есөнбулаг

Биеийн тамир, спортын газрын бүтэц,
орон тоо шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биеийн тамир, спортын газрын бүтэц, орон тооны албан тушаалын ангилал зэрэглэлийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Ж.Уранчимэг)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/160 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны
07 дугаар сарын 18-ны өдрийн 425 дугаар
захирамжийн хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Цалингийн ангилал
1	Биеийн тамир, спортын газрын дарга	1	ТЗ-4
2	Биеийн тамирын бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТҮСБ-5
3	Спортын бодлого хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТҮСБ-5
4	Тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	1	ТҮСБ-4
5	Биеийн тамир, спортын статистик, цахим мэдээллийн нэгдсэн сангийн асуудал хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
6	Бие бялдрын сорил хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
7	Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамирын асуудал хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
8	Спортын тэмцээн наадам, спортын холбоод хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
9	Өсвөрийн шигшээ баг, хүчний бэлтгэл сургуулилт хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
10	Хүүхдийн спортын асуудал хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
11	Сургалт, дасгалжуулалтын асуудал хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
12	Биеийн тамирын арга зүйчийн асуудал хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
13	Нягтлан бодогч	1	ТҮ-8
14	Хүний нөөц, бичиг хэрэг, архив хариуцсан арга зүйч	1	ТҮ-7
15	Нярав, заал зохион байгуулагч	1	ТҮ-4
16	Сантехникч, цахилгаанчин	1	ТҮ-3
17	Харуул	4	ТҮ-1
18			ТҮ-1

